

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өвөрхангай аймгийн Онцгой байдлын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨВА-2026/26/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Арвайхээр хот

2025 он

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: О.Батжаргал
Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn
Аудитын менежер: П.Хорлоосүрэн
Утас: 70323833 Цахим хаяг: KhorloosurenP@audit.gov.com
Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг
Утас: 70323108 Цахим хаяг:
Erdenetsetsegb@audit.gov.mn
Аудитор: Э.Энхбаяр
Утас: 70323833 Цахим хаяг: Enkhbayare@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173.
Утас/факс: (976) 7032 3253.
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025. 02. 02 № 43
танай _____ -ны № _____ -г

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ОНЦГОЙ
БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА,
ХУРАНДАА Д.ОДОНБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өвөрхангай аймгийн Онцгой байдлын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль, журмыг бүрэн мөрдөөгүйтэй холбоотойгоор шалгуурт бүрэн нийцээгүй гүйцэтгэгч шалгарсан байна. Уг нөхцөл байдал нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байдалд тодорхой хэмжээнд нөлөөлөх эрсдэл үүсгэж байна.

Аудитын гол асуудал

Энэхүү зөрчил нь нийцлийн аудитын шинжтэй бөгөөд худалдан авах ажиллагааны хууль, журмын хэрэгжилт алдагдсанаар байгууллагын үйл ажиллагааны хууль ёсны байдал, удирдлагын хяналт, төсвийн хөрөнгийн үр ашигт сөргөөр нөлөөлөх, цаашид ижил төрлийн зөрчил давтагдах эрсдэл үүсгэж байна. Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

6225020141

D:\Audiitiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

Бусад асуудал

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно. Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

	Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31.
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	959,958.6	1,168,828.5
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,297,988.3	8,381,886.8
	Нийт хөрөнгийн дүн	6,257,946.9	9,550,715.3
	Нийт өр төлбөрийн дүн	5,656.3	5,608.5
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,252,290.7	9,545,106.8
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,257,946.9	9,550,715.3
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	4,815,312.7	8,735,969.6
	Үйл ажиллагааны зардлын дүн	4,410,335.3	5,197,886.6
	Үйл ажиллагааны үр дүн	404,977.4	3,538,082.9
	Үйл ажиллагааны бус үр дүн	(264,816.7)	(245,266.8)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	140,160.7	3,292,816.1
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,284,072.9	1,284,072.9
	Тайлант оны үр дүн	140,160.7	3,292,816.1
	Эцсийн үлдэгдэл	6,252,290.7	9,545,106.8
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	3,918,909.2	4,551,340.8
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	3,879,044.4	4,537,540.8
	Үйл ажиллагааны ЦМГ	39,864.8	13,800.0
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	39,864.8	13,800.0
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	4,366,617.5	4,361,261.4
	Урсгал зардал	4,366,617.5	4,309,505.9
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	2,459,266.2	2,362,187.9
	Улсын төсвөөс санхүүжих	4,361,226.8	4,361,226.8
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 3,832.9 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн алдаа илэрснээс аудитын явцад алдааг бүрэн залруулж, цаашид ижил төрлийн алдааг давтан гаргахгүй байх талаар зөвлөн тусалсан.

Үүнд: Санхүүгийн тайланд хувь хүний орлогын албан татварын өр төлбөрийг бүртгээгүй байсан нягтлан бодох бүртгэлийн алдааг аудитын явцад залруулсан бөгөөд энэхүү алдаа нь алдаа, зөрчлийн дүнгийн ангилалд хамруулахгүй болно.

Аудитаар нийт 1 зөрчил илэрч албан шаардлага хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт өгөөгүй

5.2 Албан шаардлага

Аудитын түүвэрт хамрагдсан 74,800.0 мянган төгрөгийн дүнтэй хоол, хүнсний материал нийлүүлэх нээлттэй тендерийн хүрээнд ирүүлсэн баримт, материалыг тендерийн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлтүүдтэй тулган шалгахад шаардлага хангаагүй гүйцэтгэгчийг шалгаруулсан байна.

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ажил гүйлгээг бүртгэхдээ зориулалтын өглөгийн данснуудаар ангилан бүртгээгүй.	1	3,832.9			1	3,832.9	1	3,832.9				
Дүн	1	3,832.9	0	0	1	3,832.9	1	3,832.9	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Дүн	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
	0	0	0	0	0	0	0	0
Дүн	0	0	0	0	0	0	0	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Шаардлага хангаагүй гүйцэтгэгчийг шалгаруулсан байна.	1	74.8	0	0	1	74.8		
Дүн	1	74.8	0	0	0	74.8	0	0
Нийт дүн	1	74.8	0	0	1	74.8	0	0

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6217143681
ИЧЭА0059 9044094